



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/531

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Дэлэгдондов овогтой Энхзаяагийн эзэмшлийн Хэрлэн сумын 5 дугаар баг /Өндөрхаан/, Тариаланчдын гудамжинд байршилтай үйлчилгээний зориулалттай 1366м² газрыг иргэн Цэрэндавга овогтой Амгаланбаатарт 44 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.


2. Иргэн Ц.Амгаланбаатарын эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Ц.Амгаланбаатарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 161 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011031